

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	2-3
2.Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8-9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3.Менежментийн захидал.....	11
4.Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	15
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15-16
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17-18
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	19-20
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22-23
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	24
5.Хавсралт	
5.1 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	25-27
6. Албан шаардлага.....	28-30

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.21 № 06/579
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Г.ӨНӨРБАЯР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Аудитын тайлан

2.1. Оршил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Г.Өнөрбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй байх, төсвийг эдийн засгийн ангилал бүрээр оновчтой төлөвлөж, төсвийг хянуулах, биет бус хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөвлөгөөнд нэгтгүүлж байх, Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр төлөөлөн гүйцэтгүүлэгч төрийн бус байгууллагын гэрээний гүйцэтгэлд улирал бүр хяналт, шинжилгээ хийж байх зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Бат-Эрдэнэ хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/128 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, энэ чиглэлээр салбар хоорондын зохицуулалт хийх;
- Цалин хөлс, хөдөлмөрийн харилцааны оновчтой тогтолцоо, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурласан мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох, ажиллах хүчний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн амьдралын түвшнийг дээшлүүлэх;
- Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын хөгжлийг хангах нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзан хүн амын бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах;
- Салбарын хүний нөөц, удирдлагын чадавх, зохион байгуулалтыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ахplorer 3.16 программ хангамж ашигладаг байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо

олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 14 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны эхний хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт буюу 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 92,188,325.7 мянган төгрөгийн 1 хувь 921,883.3 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшнийг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 352,166.6 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо /эздийн өмч/ данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0.9	0.9
Авлага	97,864.9	218,072.0	120,207.1
Урьдчилгаа	-	160,647.1	160,647.1
Бараа материал	92,631.5	324,636.4	232,004.9
Үндсэн хөрөнгө	7,661,719.0	6,796,692.4	(865,026.6)
Нийт хөрөнгө	7,852,215.4	7,500,048.8	(352,166.6)
Өр төлбөр	1,983.0	10,745.9	8,762.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,850,232.4	7,489,302.9	(360,929.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,852,215.4	7,500,048.8	(352,166.6)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь арилжааны банк дахь жижиг мөнгөн сангийн дансны үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл өссөн нь нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэгдсэн 198,272.0 мянга, 2018 оны оноос шилжин ирсэн ном, гарын авлага хэвлүүлэхээр урьдчилж шилжүүлсэн 9,900.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Урьдчилгаа дансанд олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэж байгаа он дамжсан гэрээт ажлын урьдчилгаа төлбөр болон даатгалын үйлчилгээний төлбөрийг урьдчилж шилжүүлсэн 160,647.1 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөр байна.

Бараа материал дансны үлдэгдэлд 15,762.9 мянган төгрөгийн хөрөнгийн дансны ангиллыг данс буруу бүртгэснийг залруулсан, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүжилтээр хийгдсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн нэгдсэн системийн 220,000.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг дахин сайжруулалт хийгдсэний дараа

ашиглагч байгууллагад шилжүүлэхтэй холбоотойгоор эргэлтийн хөрөнгөнд бүртгэсэн хөрөнгө байна.

Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 10,797.0 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 38,400.0 мянга, балансаас балансад шилжүүлэн хүлээн авсан 64,000.0 мянга нийт 113,197.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлтэйгөөр 358,720.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан дүнгээр буурчээ.

Өр төлбөр данс НДШ, ХХОАТ-ын 9,225.3 мянга, шуудан холбооны 435.4 мянга, хөрөнгө бэлтгэхтэй холбоотой 1,085.2 мянга зэрэг 10,745.9 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Төсвийг зохистой удирдаагүйгээс 9,225.3 мянган төгрөгийн НДШ, ХХОАТ-ын өглөг үүсгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,489,302.9 мянган төгрөг болж 360,929.5 мянган төгрөгөөр буурсан нь 1,946.3 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга бичилт хийсэн, тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж хуримтлагдсан үр дүн данс 358,983.2 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 1,946.3 мянган төгрөгийн бичилт нь өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдаагүй өр төлбөрийн үлдэгдлийг тайлант жил барагдуулсан тул өмнөх үеийн үр дүн дансанд залруулах бичилт хийсэнтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 89,020,323.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Улсын төсвөөс 88,825,829.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 88,817,631.0 мянган төгрөг буюу 99.8 хувьтай ба зарцуулаагүй үлдэгдэл 8,282.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн зардал батлагдсан төлөвлөгөөнөөс 0.2 хувиар хэмнэгдсэн шалтгаан нөхцөлийг тодруулбал:

Засгийн газрын урсгал шилжүүлгийн зардал 3,687.0 мянган төгрөгөөр хэмнэсэн нь Цаатан иргэдийн болон Цэргийн алба хааж байсан иргэдийн НДШ-ийг төрөөс хариуцах зардлыг Нийгмийн даатгалын ерөнхий газраас нэхэмжилсэн бодит гүйцэтгэлээр шилжүүлсэн;

Ажил, олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардал 18,345.0 мянган төгрөгөөр, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардал 126,257.2 мянган төгрөгөөр хэмнэсэн нь Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7-д заасны дагуу олгогдох тэтгэмжийн зардлын зөрүүг яамны төсөвт суулгасан бөгөөд төсвийн жилийн дундуур өргөдөл, хүсэлт ирүүлсэн багш нарын материалыг хянаж, үзээд шаардлага хангасан багш нарын тэтгэмжийн зардлыг ажиллаж байгаа Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн төсөв дээр нэмж, яамны төсвөөс хасаж төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах байдлаар төсөвт зохицуулалт хийгддэг байна;

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал 49,586.7 мянган төгрөгөөр хэмнэсэн нь 2019 онд тэтгэвэрт гарах 2 албан хаагчийн тэтгэмжийг төсөвт суулгасан боловч тэтгэвэрт гарах өргөдөл хүсэлтээ ирүүлээгүйгээс тэтгэмж олгогдоогүй байна;

Нэмэлт төсөв:

Тайлант онд Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сан, Азийн хөгжлийн банк, Германы хамтын ажиллагааны байгууллага, Швейцарын хөгжлийн агентлаг, Олон улсын хөдөлмөрийн байгууллага зэрэг гадаад төсөл хөтөлбөрүүдээс 1,846,748,8 мянга, Засгийн газрын нөөц сангаас 956,903.3 мянга, бусад төсөл хөтөлбөрөөс 166,791.1 мянга нийт 2,970,443.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс 35,325.9 мянган төгрөгийг байр ашиглалттай холбоотой зардал, 147,899.6 мянган төгрөгийг хангамж материалын зардалд, 163,271.7 мянган төгрөгийг нормативын зардалд, 130,317.7 мянган төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардалд, 228,755.8 мянган төгрөгийг томилот зочны зардалд, 2,067,032.1 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 198,342.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 18 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 3,506,943.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3,215,537.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 162,401.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 81,137.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Аудитаар ажил, гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд бүртгэсэн 2,989,182.5 мянган төгрөгийн, акталж устгасан 6,355.0 мянган төгрөгийн бараа материалыг данс буруу ангилж зарцуулснаар бүртгэсэн, биет бус хөрөнгө бэлтгэсэн 220,000,0 мянган төгрөгийн ажлыг хөрөнгийн орлого авалгүйгээр шууд зардлаар бүртгэж санхүүгийн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны зардлыг илүү илэрхийлсэн зэрэг нийт 3,215,537.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг санхүүгийн тайланд залруулгыг хийлгэв.

2. Монгол Улсын Засгийн газрын яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай 2016 оны 3 дугаар тогтоолоор (2018 оны 110 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон) Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны орон тооны хязгаарыг 119 байхаар тогтоосны дагуу тус яамны ТНБД-ын 2018 оны А/171 дүгээр тушаалаар " Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны чиг үүргийн хуваарийг шинэчлэн баталсан боловч бүтцийн нэгжийн үндсэн орон тоонд жолооч, харуул, нярав, нягтлан бодогч зэрэг төрийн үйлчилгээний 13 орон тоо батлагдаагүй тул тэдгээр орон тооны ажилтнуудын цалин, НДШ-ийн зардлыг 80226- байр ашиглалтын үйлчилгээ зориулалт арга хэмжээний 210801- бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын эдийн засгийн ангилал дээр төлөвлөн Сангийн яамаар хянуулж, төсвийг батлуулж ирсэн бөгөөд 2019 оны гүйцэтгэлээр 152,476.3 мянган төгрөгийн зардлыг дээрх зардлаас санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь " батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 22 дугаар зүйлийн 22.6 -д Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үе шат бүрд төсвийн ангиллыг дараах байдлаар хэрэглэнэ: 22.6.3-д "төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх", Сангийн сайдын 2014 оны 5 тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан " Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ын Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал : 2101- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил –“ Ажиллагсдын цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд энэ ангилалд хамаарна”..., 2102-Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл “Ажил олгогчоос буюу төсөвт байгууллагаас тайлангийн хугацаанд Нийгмийн даатгалын болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан хувь хэмжээгээр үндсэн болон нэмэгдэл цалин, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын

шимтгэлийг тооцож, энэ ангилалд бүртгэнэ” эдгээр зардлуудыг бүлгийн дүнгээр хянана, 2108-Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж: “байгууллага гуравдагч этгээдийн багц ажил, үйлчилгээг худалдан авч, үйл ажиллагаа эрхлэхэд гарах зардлыг энэ ангилалд бүртгэнэ.” Эдгээр бүлгийн зардлуудыг эдийн засгийн ангилал бүрээр хянана”, 2015 оны 7 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал"-ын 21 -Урсгал зардал, 210-Бараа, ажил үйлчилгээний зардал.; 2101-Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, (210101-210105), 2102-Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, (210201-210205), 210801: Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, 4 дүгээр хавсралтаар баталсан " Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал"-ын 80100-Үйл ажиллагааны урсгал зардлын зориулалт, 80226-Байр ашиглалтын үйлчилгээ” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй ба Үнэн зөв байдал батламж, мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3. Цалингийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулаагүй, дансны өр төлбөрийн тооцоог хянаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд ХХОАТ, НДШ-ийн 9,925.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заасантай нийцээгүй, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 81,137.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрийн өр төлбөрийн үлдэгдэлтэй холбоотой асуудлыг дараагийн шатны буюу Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийх аудитын түвшинд авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 106 мэдээллийг хугацаанд нь, 36 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 102,182.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлснээс 73,887.2 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хэрэгжүүлсэн ба бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас зориулалт бус зардал гаргасан зөрчлийг давтан гаргасан байна. Нийт 2 зөвлөмж өгснөөс бүрэн хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 243,569.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 921,883.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгөв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой тусгав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал:

3.1.1 Илрүүлэлт:

Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын эдийн засгийн ангиллын бүлэг хооронд нийт 29.905.5 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6-д “... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийн бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулагдах, санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсөвт зохицуулалт хийх зайлшгүй шаардлага үүсвэл төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмыг мөрдөж, дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөл авч байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Сангийн яамнаас 2016 оноос хойш үндсэн үйл ажиллагааны зардал дээр цалингийн зардлаас бусад зардлыг нэмэгдүүлээгүйгээс бусад зардал хүрэлцдэггүй, тул оны эхэнд ХНХС тушаалаар Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрөөс санхүүжүүлэх арга хэмжээний хуваарийг гарган зарим, арга хэмжээг санхүүжүүлж ирсэн.

3.2 Авлагын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаагүйгээс 2018 оноос шилжин ирсэн 9,900.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-дахь “төсвийг зохистой удирдаж

авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, санхүүгийн тайланд найдваргүй авлага үүсэх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж, он дамжсан авлага үүсгэхгүй байх, 2020 оны 1 дүгээр улиралд багтааж дээрх авлагыг барагдуулах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Салбарын хууль, тогтоомжийн эмхэтгэл хэвлүүлэх гэрээг байгуулсан боловч 2019 онд зарим, хууль тогтоомжид өөрчлөлт орсонтой холбоотойгоор хэвлэлийн эхэд өөрчлөлт орсноос шалтгаалан ажил, удааширсан болно. 2020 оны 1 дүгээр сард багтаан хэвлэлтээс гарахад бэлэн болсон байгаа.

3.3. Зардалтай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Ажилтан, албан хаагчдын хөдөө орон нутагт ажиллахад байгууллагын автомашинд зарцуулсан 7,768.6 мянган төгрөгийн шатахууны зардлыг дотоод албан томилолтын зардлаас санхүүжүүлж байгаа нь Сангийн сайдын 2014 оны 5 тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар", 2015 оны 7 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан " Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал", 2 дугаар хавсралтаар баталсан " Зардлын эдийн засгийн ангилал", -ын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй ба үнэн зөв, толилуулга байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Төсвийг үндэслэлтэй төлөвлөхгүй байх, дотоод албан томилолтын зардал хүрэлцэхгүй байх.

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагад шаардагдах тээвэр шатахууны зардлыг Сангийн сайдын 2014 оны 5 тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ыг үндэслэн тээвэр шатахууны зардлын эдийн засгийн ангилал дээр нэгтгэн төлөвлөж, төсвийг хянуулж байх.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Сангийн яамнаас төсвийн санал хүлээн авахдаа дотоод албан томилолтын зардал болон бусад холбогдох шатахууны зардлыг 210701 буюу дотоод албан томилолтын зардлын эдийн ангилал дээр хамтад нь хянаж, баталдаг.

3.4 Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Биет бус хөрөнгө дансанд вирусийн программыг буруу ангилж бүртгэсэн, цаашид ашиглах боломжгүй хэрэгцээ шаардлагагүй болсон, ажиллуулах мэргэжилтэнгүй улмаас ашиглаагүй график дизайны, статистик анализын программ зэрэг нийт 33,563.5 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл: Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах, 31.1 -д “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

3.4.2. Эрсдэл:

Хөрөнгийг үр ашигтай ашиглаагүй байх, ашиглах боломжгүй болсон биет бус хөрөнгийг акталж, данснаас хасаагүй байх, данс буруу ангилж бүртгэсэн байх.

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Ашиглагдаагүй байгаа программ хангамжийн ашиглалтыг сайжруулж, хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, цаашид ашиглах боломжгүй болсон программ хангамжийг актлах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлж, данс бүртгэлээс хасах.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа график дизайн, статистик анализын программ хангамж нь ашиглах боломжтой боловч одоогоор ашиглаж байгаа мэргэжилтэнгүй байна. Шагналын болон вирусийн программууд нь элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжгүй байгаа тул актлуулах саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

3.5. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

3.5.1. Илрүүлэлт:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төсвийн шууд захирагч нь 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланд нэгтгүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах", Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 1.5-д "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг дараах шатлалаар нэгтгэн, баталж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлнэ", 1.5.2-т "Төсвийн төвлөрүүлэн захирагчгүй бол төсвийн шууд захирагч нь төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ" заасантай нийцэхгүй байна.

3.5.2. Эрсдэл:

Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчим алдагдах.

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журамд заасны дагуу төлөвлөгөө, тайланг боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөвлөгөө, тайланд нэгтгүүлж байх.

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулна.

3.6. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.6.1. Илрүүлэлт:

Төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээний дагуу санхүүжүүлсэн Төрийн бус байгууллагуудын төлөвлөгөөний биелэлтэд улирлаар бус жилийн эцэст нэг удаа хяналт, шинжилгээ үнэлгээ хийж байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалт болон хамтран ажиллах гэрээний холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

3.6.2. Эрсдэл:

Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний гүйцэтгэлд тавих хяналт сул байх, төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх.

3.6.3. Өгсөн зөвлөмж:

Гэрээний гүйцэтгэлд улирал бүр хяналт, шинжилгээ мониторинг хийж хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах.

3.6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Засгийн газрын тогтоолын дагуу Монголын ахмадын холбоо, Монголын улаан загалмайн нийгэмлэгтэй жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулж, үйл ажиллагааны тайланг улирал бүр хүлээн авч, жилийн эцэст хяналт, шинжилгээ үнэлгээг дотоод аудитын газраас хийж, дүгнэлт гаргадаг. Үнэлгээгээр гүйцэтгэл 90-100 хувьтай үнэлэгддэг .

3.7. Гадаад томилолттой холбоотой асуудал

3.7.1. Илрүүлэлт:

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын албан хүсэлт болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалыг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхлэх асуудлын хүрээний буюу хүн амын бүлгийн асуудлаар Америкийн нэгдсэн улсад зохион байгуулагдсан Нэгдсэн үндэсний байгууллагын чуулганд оролцсон улс төрийн албан тушаалтны томилолтын зардлыг байгууллагын төсвөөс олгосон боловч, томилолтоор ажилласан ажлын тайланг хүлээн авч үр дүнг тооцоогүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл: Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх 6.6.6-д “ тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” заалттай нийцэхгүй байна.

3.7.2. Эрсдэл:

Төсвийн тухай хууль зөрчигдөх, батлагдсан төсөв зориулалт бусаар зарцуулагдах.

3.7.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид Засгийн газар, УИХ-ын албан ёсны тогтоол, шийдвэрт үндэслэн дээрх зардлыг санхүүжүүлж байх, томилолтоор ажилласан ажлын тайланг хүлээн авч, үр дүнг тооцож байх.

3.7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхлэх асуудлын хүрээний буюу Хүн амын бүлгийн асуудлаар Нэгдсэн үндэсний байгууллагын чуулганд төлөөлөгчөөр оролцсон.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	190,496,400.24	703,356,400.59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	900.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	900.00
31210	Төгрөг	0.00	900.00
31213	Арилжааны банк дахь харилцах	0.00	900.00
33	АВЛАГА	97,864,945.47	218,072,045.82
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,182,243.50	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	71,862,701.97	198,272,045.82
33500	Бусад авлага	13,820,000.00	19,800,000.00
33510	Байгууллагаас авах авлага	13,820,000.00	19,800,000.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	160,647,070.00
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	160,647,070.00
35	БАРАА МАТЕРИАЛ	92,631,454.77	104,636,384.77
35400	Хангамжийн материал	92,631,454.77	104,636,384.77
35410	Бичиг хэргийн материал	35,151,046.30	57,783,120.00
35420	Аж ахуйн материал	42,328,708.47	32,642,378.47
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	300,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,582,400.00	1,272,400.00
35470	Бусад хангамжийн материал	12,569,300.00	12,638,486.30
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.00	220,000,000.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	0.00	220,000,000.00
